

ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
ТОЛЯТИГИЙН РАЙСАГИЙН
2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
Нэгжийн нэр: Хууль, эрх зүйн хэлтэс

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1. Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, хууль, хяналтын байгууллагуудын уялдаа холбоог хангах.					
1.	Арга хэмжээ 1.1.	50	10	60	
2.	Арга хэмжээ 1.2.	50	10	60	
3.	Арга хэмжээ 1.3.	60	5	65	
Зорилт 2 Нийтийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалт, сурталчилгааг зохион байгуулах, иргэд, аж ахуйн нэгж байгууллагад хууль, эрх зүйн тусалцаа үзүүлэх, тайлагнах.					
1.	Арга хэмжээ 2.1.	60	10	70	
Зорилт 3 Байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх					
1.	Арга хэмжээ 3.1.	60	10	70	
2.	Арга хэмжээ 3.2.	60	10	70	
3.	Арга хэмжээ 3.3.	60	10	70	
4.	Арга хэмжээ 3.4.	60	10	70	
5.	Арга хэмжээ 3.5.	60	10	70	
6.	Арга хэмжээ 3.6.	50	5	55	
Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт					
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.	60	10	70	
2.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2.	50	10	60	
3.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3.	60	10	70	
Дундаж оноо:				66,2	

Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Арга хэмжээ 1.		12	
2.	Арга хэмжээ 2.		10	
Дундаж оноо			11	

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	7	
2.	Дүн шинжилгээ хийх	7	
3.	Асуудал шийдвэрлэх	7	
4.	Хариуцлагатай байдал	7	
5.	Ажлын цаг ашиглалт	7	
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6.	Мэргэжлийн ур чадвар 1.		
7.	Мэргэжлийн ур чадвар 2.		
8.	Мэргэжлийн ур чадвар 3.		
Дундаж оноо		7	

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	5
2.	Багаар ажиллах	6
3.	Харилцаа	5
Дундаж оноо		5,3

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)	(70 хүртэлх оноо) 66,2
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	(15 хүртэлх оноо) 11
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	(7 хүртэлх оноо) 7
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	(8 хүртэлх оноо) 5,3
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	(..... оноо) 89,5
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		89,5

Үнэлгээ өгсөн:

Хууль, эрх зүйн хэлтсийн даргын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

.....

/Б.ОЧИР/
2025.06... (огноо)

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Хууль, эрх зүйн хэлтсийн
мэргэжилтэн

Төрийн жинхэнэ албан хаагч:

.....

/Л.РАЙСА/
2025.06... (огноо)

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

Төрийн захиргааны удирдлагын
хэлтсийн даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч

.....

/О.МӨНГӨНШАГАЙ/

2025.06.09 (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

Хүний нөөц, хөрөнгө орлогын мэдүүлэг
хариуцсан ахлах мэргэжилтэн

.....

/Б.САРАНЦАЦРАЛ/

2025.06.09 (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан:

Засаг даргын Тамгын газрын
даргын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч



/З.БУЯНТ/

2025.06.10 (огноо)

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
Т.РАЙСАГИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)			
	1	2	3	4	5		6	7
Зорилт 1. Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, хууль, хяналтын байгууллагуудын уялдаа холбоог хангах.								
1.	Арга хэмжээ 1.1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулна.	Сургалт, өдөрлөгт хамрагдсан иргэн, албан хаагчдын тоо	4 сургалт, 1 арга хэмжээ зохион байгуулж 800 иргэн, аж ахуй нэгж байгууллагыг хамруулсан.	1 сургалт зохион байгуулж 100 иргэн, албан хаагчийг хамруулна.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Авлигатай тэмцэх газар, дүүргийн Цагдаагийн газартай хамтран 2 сургалт зохион байгуулж 88 иргэн, албан хаагчийг хамруулсан. Үүнд: 1. “Худалдан авах ажиллагаанд авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг Үнэлгээний хорооны албан хаагчдад 2. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидаг согтуурахтай тэмцэх тухай хуулийн холбогдох заалтын хүрээнд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэх эрсдэлтэй зорилтод бүлгийн иргэдэд мэдээлэл хүргэж ажилласан.		2025.02.13 2025.04.04	95%

2.	Арга хэмжээ 1.2. Өсвөр үе, залуучуудад согтууруулах ундаа, мансууруулах төрлийн бодис хэрэглэх хорт зуршлаас урьдчилан сэргийлэх болон цахим дээрэлхэлтээс ангид байх, хувь хүний хөгжлийг дэмжих эрх зүйн сургалт, зохион байгуулна.	Зохион байгуулсан сургалт болон өдөрлөг, хамрагдсан сурагчдын тоо	4 сургалт, 1 арга хэмжээ зохион байгуулж 2000 иргэн, сурагчийг хамруулсан.	2 сургалт зохион байгуулж 200 иргэн, сурагчийг хамруулна.	Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбан зөвлөл, дүүргийн Цагдаагийн газар Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэстэй хамтран 3 сургалт зохион байгуулж 150 сурагчийг хамруулсан. Үүнд: 1. “Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь”, “Электрон тамхины хор уршиг” 2. “Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг авах” сэдэвт сургалтуудыг тус тус зохион байгуулж ажилласан.	2025.03.21 2025.04.07	100%
3.	Арга хэмжээ 1.3. Хууль, тогтоомжоор хүлээлгэсэн мэдээ, тайланг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлнэ.	Хэрэгжилтийн хувь	3 удаа тайлан хүргүүлсэн.	Тайланг хугацаанд нь 100% хүргүүлсэн байна.	Хан-Уул дүүрэгт эхний хагас жилд хийж хэрэгжүүлсэн эрх зүйн ажлын тайланг нэгтгэж ЗДТГ-ын даргын 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 04/898 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай 2025 онд байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний биелэлтийг нэгтгэж ЗДТГ-ын даргын 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 04/... дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тус тус хүргүүлсэн.	2025.02.27 2025.05.01	100%
Зорилт 2. Нийтийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалт, сурталчилгааг зохион байгуулах, иргэд, аж ахуйн нэгж байгууллагад хууль, эрх зүйн туслалцаа үзүүлэх, тайлагнах.							
4.	Арга хэмжээ 2.1. Хууль тогтоомж, хэм хэмжээ тогтоосон	Зохион байгуулсан сургалт,	10 сургалт зохион байгуулж,	2 сургалт зохион байгуулж, 250	Хууль, эрх зүйн хэлтсээс зохион байгуулах сургалтын төлөвлөгөөний дагуу эрх зүйн 5	2025.01.24 2025.04.25	100%

	захиргааны актыг тайлбарлах, эрх зүйн сургалт, сурталчилгааг иргэд, албан хаагчдад зохион байгуулна.	хамрагдсан иргэд, албан хаагчдын тоо	1850 иргэн, албан хаагч, сурагч хамрагдсан.	иргэн, албан хаагчийг хамруулна.	сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 310 иргэн, албан хаагчийг хамруулсан. 1. Хөдөлмөрийн тухай хууль (шинэчилсэн найрууллага) 2. “Захиргааны актын тухай ойлголт, хуульчлагдсан байдал, захиргааны актад тавигдах нийтлэг шаардлага” 3. Зөвшөөрлийн тухай хууль болон Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журмын талаарх танилцуулга 4. “Өв залгамжлалын харилцаанд нотариачийн хүлээх үүрэг” 5. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон “Төрийн албан хаагчдад тавигдах нийтлэг шаардлага” сэдэвт сургалтуудыг тус тус зохион байгуулсан		
Зорилт 3. Байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.							
5.	Арга хэмжээ 3.1. Дүүргийн цахим хуудаст хууль тогтоомж болон хэм хэмжээ тогтоосон захиргааны актын талаарх мэдээллийг тогтмол байршуулж баяжилт хийх.	Мэдээллэсэн захирамжийн тоо	140 захирамж байршуулсан	-	Дүүргийн цахим мэдээллийн www.khanuul.mn цахим санд дүүргийн Засаг даргын 2025 оны эхний хагас жилд 45 захирамжийг байршуулсан.	2025.01.05 2025.05.01	100%
6.	Арга хэмжээ 3.2. Иргэд, байгууллагаас ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт, мэдээллийг судлан, хуулийн дагуу шийдвэрлэн хариу өгөх.	Шийдвэрлэлт ийн хувь	8 өргөдөл гомдол хүлээн авч хуульд заасны дагуу шийдвэрлэсэн	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	-Албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн системээр нийт 36 албан бичиг хүлээн авч шийдвэрлэн, 20 албан бичиг төлөвлөн явуулсан. -Өргөдөл гомдол 5 ирснийг хуулийн хугацаанд судалж шийдвэрлэн, иргэнд хариу өгч ажилласан.	2025.01.05 2025.05.01	100%

7.	Арга хэмжээ 3.3. Баримт бичгийг албан бичгийн стандартын дагуу зохион бүрдүүлэх, архивын стандартад нийцүүлэн байгууллагын архивт хадгаламжийн нэгжийг хүлээлгэн өгнө.	Хүлээлгэн өгсөн хадгаламжийн нэгжийн тоо	9 хадгаламжийн нэгж хүлээлгэн өгсөн	9-өөс доошгүй хадгаламжийн нэгж хүлээлгэн өгнө.	2024 оны байгууллагын Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу байнга хадгалах 7, түр хадгалах 8 нийт 15 боть баримтыг 2025 оны 04 дугаар сарын 01-ний өдөр архив албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу бүрдүүлж дүүргийн архивд актаар хүлээлгэн өгсөн.	2025.01.05 2025.04.01	100%
8.	Арга хэмжээ 3.4. Төрийн албан хаагчийн ёс зүйг чандлан мөрдөж ажиллана.	Ёс зүйн зөрчил гаргасан эсэх	Ёс зүйн зөрчилгүй ажилласан.	Ёс зүйн зөрчилгүй ажиллана.	Ёс зүйн зөрчилгүй ажилласан.	2025.01.05 2025.05.01	100%
9.	Арга хэмжээ 3.5. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.	Үйл ажиллагааны хувь	Хэрэгжилтийг хангасан байна.	100%	Дүүргийн нутаг дэвсгэрт шинээр байгуулагдсан нийт 10 сууц өмчлөгчдийн холбооны бичиг баримтыг хуульд нийцүүлэн нягтлан шалгаж ажилласан.	2025.01.05 2025.05.01	100%
10.	Арга хэмжээ 3.6. Удирдлагаас цаг үеийн шинж чанартай өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, Ажлын цагийг үр бүтээлтэй ашиглах	Үйл ажиллагааны хувь	Үүрэг даалгаврыг хугацаанд нь бүрэн биелүүлсэн.	Өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд 100% биелүүлсэн байна.	Дүүргийн Засаг даргын 4 захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт гишүүнээр томилогдон ажиллаж, холбогдох Хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээллийг өгч, үүрэг даалгаврыг тухай бүр биелүүлж ажилласан. Үүнд: 1. Хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт боловсруулах ажлын хэсэг 2. Хот нийтийн аж ахуйн ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажлын хэсэг 3. Агаар бохирдуулагч эх үүсвэрийн судалгаа гаргах, хяналт шалгалт хийх ажлын хэсэг 4. "Газрын зөрчил арилгаж, албадан чөлөөлөх арга	2025.01.05 2025.05.01	100%

					хэмжээний тухай” захирамжийн дагуу ТҮЦ нүүлгэх ажлын хэсэг Мөн Хүний эрхийг хангах Үндэсний хорооноос баталсан “Орон нутаг дахь хүний эрхийн төлөв байдлыг тайлагнах, илтгэх журам”-ын дагуу дүүрэг дэх 2024 оны хүний эрхийн төлөв байдлын танилцуулгыг Төрийн бүтээмжийн үндэсний хороонд хүргүүлж, цахим хэлбэрээр танилцуулж ажилласан.		
НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАРЫН БИЕЛЭЛТ							
1.	Үүрэг даалгавар 1. Хөдөлмөрийн, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооны 2022 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 16 дугаар тогтоолоор Хан-Уул дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороог байгуулж Хөдөлмөрийн тухай хуульд заасан эрхийн маргааныг урьдчилан шийдвэрлэх арга хэмжээг авах	Хэрэгжилтийн хувь	52 иргэний хүсэлтийг хүлээн авч хороогоор хэлэлцүүлэн хуулийн хүрээнд шийдвэрлэж ажилласан.	Хороонд ирсэн хүсэлтийг хуулийн хүрээнд шийдвэрлэсэн байна.	Хан-Уул дүүргийн Хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороо 67 аж ахуйн нэгж байгууллагын 60 иргэний гомдлыг хүлээн авч, хялбаршуулсан журмаар 7 иргэн, гурван талт хорооны хурлаар 67 иргэний хүсэлтийг тус тус хэлэлцэн хуулийн хүрээнд шийдвэрлэсэн.	2025.01.05 2025.05.01	100%
2.	Дүүргийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/202 дугаар “Газрын зөрчил арилгаж, албадан чөлөөлөх арга хэмжээ авах тухай” захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Хэрэгжилтийн хувь	-	Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Дүүргийн нутаг дэвсгэрт иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг зөрчиж нийтийн эзэмшлийн зам талбай, авто болон явган хүний замыг хаасан, тохижилт ногоон байгууламж дээр зохих зөвшөөрөлгүйгээр байршуулсан түргэн үйлчилгээний цэг (ТҮЦ), стандарт шаардлага хангахгүй дугуйт байгууламж, зөөврийн байгууламжийг нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаанд ажилласан. Нийт	2025.01.05 2025.05.01	100%

					170 ТҮЦ нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаанд оролцсон.		
3.	Дүүргийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/45 дугаар "Хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай" захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Хэрэгжилтийн хувь	-	Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын хэсгийн 4 удаагийн хуралд оролцож, санал өгч ажилласан. Мөн Засаг даргын дэргэдэх 6 хэлтсийн хариуцлагын гэрээнд хяналт шинжилгээ, үнэлгээний үед хамаарах 2 заалтыг тусгуулж ажилласан.	2025.01.05 2025.05.01	100%

ХОЁР. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)			
	1	2	3	4	5		6	7
10	Арга хэмжээ 2.1. Дээд шатны байгууллага, Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан сургалтад идэвхтэй хамрагдана.	Хамрагдсан сургалтын тоо	3 удаагийн сургалтад хамрагдсан	1 удаагийн сургалтад хамрагдсан байна.	Нийслэл, дүүргээс зохион байгуулсан дараах сургалтад хамрагдсан. 1. "Төрийн албан хаагчдад тавигдах ёс зүйн нийтлэг шаардлага болон Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль", "Удирдах ажилтны манлайлал" 2. "Хувь хүний соёл, ажил хэрэгч харилцаа" 3. "Болзошгүй аюулын үед өөртөө болон бусдад анхны тусламж үзүүлэх чадвар олгох" 4. "Хяналт шинжилгээ хийх", "Үнэлгээ хийх", "Байгууллагын үйл ажиллагааг үнэлэх" журмын танилцуулга		2025.02.01 2025.05.01	100%

				5. “Цахим орчны боломж ашиглан ажлын бүтээмж нэмэгдүүлэх нь” Мөн Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багш” бэлтгэх сургалтад хамрагдаж “Гэрчилгээ” гардаж авсан. Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс зохион байгуулсан “Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөл байршуулах, хэлэлцүүлэх, олон нийтээс санал авах систем” сэдэвт хэлэлцүүлэгт хамрагдсан.			
11	Арга хэмжээ 2.2. Улс нийслэл, дүүргээс зохион байгуулсан олон нийтийн арга хэмжээ, уралдаан тэмцээн, сургалтад тогтмол хамрагдах	Үйл ажиллагааны хувь	11 арга хэмжээнд оролцсон.	Арга хэмжээнд тухай бүр хамрагдсан байна.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Зарлигаар "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн "Ногоон хот - Иргэний оролцоо" мод тарих өдөрлөгт хэлтсийн албан хаагчдын хамт оролцсон.	2025.02.01 2025.05.01	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:
ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



Т.Райса

2025 оны 06 дугаар сарын...06

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТ, СОЁЛ УРЛАГИЙН
АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ТОЛЯТИГИЙН РАЙСАГИЙН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дуусан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Стратегийн төлөвлөгөөний зорилго 7. "Төрийн үйлчилгээг иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлнэ".							
Зорилт 1. Биеийн тамир, спорт, соёл урлагийн талаарх хууль тогтоомж, төрөөс баримталж буй бодлого, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах, тайлагнах							
1.	Арга хэмжээ 1.1 Дүүргийн "Иргэдийн спортын их наадам"-ыг жил бүр өргөн хүрээтэй зохион байгуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	Хамрагдсан иргэдийн тоо	6500	6500-аас доошгүй иргэн	Бүс, орон нутгийн нэгдмэл байдлыг бэхжүүлэх, бүсүүдийн хамтын ажиллагааг спортоор дамжуулан өргөжүүлэх, үндэсний болон спортоор хичээллэх, эрүүл идэвхтэй амьдралын хэв маягтай иргэдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор Бүсчилсэн хөгжлийн иргэдийн спортын их наадмыг 2025 оны 05 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн спортын 7 төрлөөр зохион байгуулан ажиллаж байна. Волейболын тэмцээнийг 2025 оны 05 дугаар сарын 17, 18-ны өдрүүдэд, сагсан бөмбөгийн тэмцээнийг 24, 25-ны өдрүүдэд 3 насны ангиллаар бүсчилсэн хэлбэрээр тус тус зохион байгуулж, 25 хорооны 800 гаруй тамирчин хамрагдсан. Иргэдийн спортын их наадам 06 дугаар сарын 08-ны өдрийг хүртэлх хугацаанд үргэлжилнэ.	2025.05.17 2025.06.08	30%
2.	Арга хэмжээ 1.2 "Улаанбаатар марафон-2025" олон улсын гүйлтийн арга хэмжээнд иргэдийг идэвхтэй оролцуулна.	Хамрагдсан иргэдийн тоо	6600	6600-аас доошгүй иргэн	Нийслэлийн Засаг даргын захирамжаар жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг "Улаанбаатар марафон-2025" Олон Улсын гүйлтийн арга хэмжээ 2025 оны 05 дугаар сарын 24-ний өдөр Д.Сүхбаатарын талбайд зохион	2025.05.24- 2025.05.24	100%

					байгуулагдсан. Тус гүйлтийн арга хэмжээнд Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын 2200 гаруй ажилтан, албан хаагч, дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллага, хороо, төр хувийн хэвшлийн нийт 247 байгууллагын 6500 гаруй ажилтан, албан хаагч, иргэд хамрагдсан. “Улаанбаатар марафон 2025” өдөрлөгийн арга хэмжээг Гадаад харилцааны яамны автомашины зогсоолд 11:00-17:00 цагийн хооронд зохион байгуулж, батлагдсан хөтөлбөрийн дагуу өдөрлөгт оролцогч иргэдэд зориулсан соёл урлагийн арга хэмжээ болон спортын 4 төрлийн тэмцээн уралдааныг зохион байгуулсан.		
3.	Арга хэмжээ 1.3 Автомашингүй өдөр нэгдсэн арга хэмжээнд иргэдийг идэвхтэй оролцуулна.	Хамрагдсан иргэдийн тоо	350	370	Хэрэгжих хугацаа болоогүй.	-	0%
4.	Арга хэмжээ 1.4 “Дээлтэй Монгол наадам-2024” арга хэмжээнд оролцоно.	Хамрагдсан иргэдийн тоо	700	500	Хэрэгжих хугацаа болоогүй.	-	0%
5.	Арга хэмжээ 1.5 Өвлийн спортын арга хэмжээг зохион байгуулна.	Хамрагдсан хүний тоо	1153	1100	Хэрэгжих хугацаа болоогүй.	-	0%
6.	Арга хэмжээ 1.6 Д.Лувсаншаравын нэрэмжит Найрал дууны уралдаан зохион байгуулна.	Хамрагдсан сурагчдын тоо	1100	1100-аас доошгүй сурагч хамруулна	Хэрэгжих хугацаа болоогүй.	-	0%

Зорилт 2.Биеийн тамир, спорт, соёл урлагийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай судалгаа шинжилгээ хийж, хяналт тавих							
1.	Арга хэмжээ 2.1 Дүүргийн хүүхэд, залуучуудыг авьяас хөгжүүлэх олон талт сургалтад хамруулна.	Хамрагдсан хүүхдийн тоо	150	70	Соёлын ордны авьяас хөгжүүлэх 5 төрлийн сургалтад нийт 150 хүүхэд хамрагдан хичээллэж байна. Хөгжлийн бэрхшээлтэй 3 хүүхэд, нийгмийн хариуцлагын хүрээнд 4 хүүхдийг үнэ төлбөргүй хамруулж байна. Дугуйлангийн сурагчдын тайлан тоглолтыг 2025 оны 05 дугаар сард зохион байгуулж, цахим орчинд түгээсэн. Нийт 10.200 хүний хандалт авсан.	2025.05.11 2025.05.20	80%
2.	Арга хэмжээ 2.2 Хотын соёлт иргэнийг төлөвшүүлэхэд бүх шатны боловсролын байгууллагуудыг хамарсан төсөл, арга хэмжээ хэрэгжүүлнэ.	Хэрэгжилтийн хувь	100%	100%	"Хотын соёлд-Бидний оролцоо" цахим контентын уралдааныг 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрөөс 03 дугаар сарын 25-ны өдрүүдэд төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын 10-12 дугаар ангийн сурагчид мөн төрийн өмчийн сургуулийн өмнөх боловсролын багш, ажилчид, эцэг эхчүүдийн дунд зохион байгуулж, 32 байгууллагын 1,500 гаруй иргэд, сурагчдыг хамруулан 42 бичлэг хүлээн авч Насан туршийн суралцахуйн төвийн фэйсбүүк пэйж хуудсанд байршуулан 86,647 хүний хандалт, 10,566 лайк, 7,768 иргэн коммент, 13,052 иргэн шейр хийж олон нийтэд түгээсэн.	2024.01.02- 2024.12.02	100%
3.	Арга хэмжээ 2.3 Соёлын биет өвийг сэргээн засварлах, хамгаалах, хөгжүүлэх болон өвлүүлэх чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулна.	Хэрэгжилтийн хувь	100%	100%	Засгийн газрын 2021 оны 179 дүгээр тогтоолоор Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтад орсон Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт байх "Туулын Хар түнийн ордны туурь", 11 дүгээр хороонд байх "Богд хааны ногоон ордны цогцолбор", "Богд хааны ногоон ордны өмнөх 2 ширхэг чулуун арслан", Нийслэлийн хамгаалалтын зэрэглэлд байх "Богд хааны хүрэн ордны зарим байшин" зэрэг түүх, соёлын 4 дурсгалын хадгалалт, хамгаалалтыг гэрээгээр хариуцуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.	2025.05.23	40%
Зорилт 3.Байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх							
1.	Арга хэмжээ 3.1	Шийдвэрлэлтийн хувь	100%	100%	2025 онд албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн системээр 7 албан бичиг ирснийг судалж	2025.05.01 2025.06.05	100%

	Албан хэрэг хөтлөлтийн үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж, ERP програмын хэрэглээг хэвшүүлэн иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол, албан бичгийг хуулийн хугацаанд нь чанартай шийдвэрлэнэ.				шийдвэрлэсэн. Харилцагч байгууллагууд руу 59 албан бичиг төлөвлөж хүргүүлсэн. Энэ хугацаанд 1 өргөдөл ирснийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, иргэнд өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хариуг өгч ажилласан.		
2.	Арга хэмжээ 3.2 Албан хэрэг хөтлөх, бүрдүүлэх, эмх цэгцтэй хадгалах, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, баримт бичгийг боловсруулах, зохион байгуулах MNS5140:2011 стандартыг мөрдөн байгууллагын архивт хүлээлгэн өгнө.	Хүлээлгэн өгсөн хадгаламжийн нэгжийн тоо	5	5	Байгууллагын 2024 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2024 оны 5 хадгаламжийн нэгжийг архивын стандартын дагуу бүрдүүлж, 2025 оны 1 дүгээр улиралд байгууллагын архивт хүлээлгэн өгсөн.	2025.05.01 2025.06.05	100%
3.	Арга хэмжээ 3.3 Ажлын цаг, цаг ашиглалтын зөрчилгүй ажиллана.	Цаг ашиглалтын хувь	100%	100%	Ажлын цаг ашиглалт зөрчилгүй.	2025.05.01 2025.06.05	100%
4.	Арга хэмжээ 3.4 Төрийн албан хаагчийн ёс зүйг чандлан мөрдөж ажиллана.	Хэрэгжилтийн хувь	100%	100%	Ёс зүйн зөрчилгүй ажилласан.	2025.05.01 2025.06.05	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

БИЕИЙН ТАМИР, СПОРТ, СОЁЛ УРЛАГИЙН
АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

(Албан тушаал)

Т.РАЙСА /

(Нэр, гарын үсэг)

2025.06.10

(Огноо)